

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ҮНЭЛГЭЭНИЙ ДҮН
2009 оны жилийн эцсийн байдлаар

№	Үзүүлэлт		Үр дүнгийн үнэлгээ	
			хувь	оноо
1	Бодлогын зорилтын хэрэгжилтийн үр дүнгийн үнэлгээ	1.Үндэсний хөгжлийн цогц бодлогын хэрэгжилт/тухайн жилд төлөвлөсөн ажил/	85.7	4.29
		2.Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	90.8	4.54
		3.Үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилт	80.0	4.00
Үнэлгээний дундаж оноо			85.50	4.28
2	Бодлогын зорилтын хэрэгжилтийн зохицуулалтын үнэлгээ	1.Монгол улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт	76.8	3.84
		2.Хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилт	89.0	4.45
		3.Монгол улсын Ерөнхий сайдтай байгуулсан батламжийн хэрэгжилт	96.8	4.84
		4.Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	92.0	4.60
Үнэлгээний дундаж оноо			88.65	4.43
3	Байгууллагын үйл ажиллагааны үр дүнгийн үнэлгээ	2.Төсвийн ерөнхийлөн захирагчаас ерөнхий менежертэй байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлт	90.0	4.50
Үнэлгээний дундаж оноо			90.00	4.50
4	Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлын үнэлгээ	1.Үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдал	93.3	4.67
		2.Хүний нөөцийн бодлогын ил тод байдал	80.6	4.03
		3.Төсөв, санхүүгийн ил тод байдал	93.6	4.68
		4.Бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдал	86.0	4.30
Үнэлгээний дундаж оноо			88.38	4.42
5	Үйл ажиллагааны үр дагаврын үнэлгээ	1.Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн үнэлгээ	90.4	4.52
		2.Хэрэглэгчийн үнэлгээ	68.2	3.41
Үнэлгээний дундаж оноо			79.30	3.97
Ерөнхий үнэлгээ			86.37	4.32

Жич: Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр болон аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг тухайн жилд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ажлын хэрэгжилтийн хувиар тооцож тавьсан болно. Хэрвээ нийт 4 жилд хэрэгжүүлэхээр тавьсан зорилтоос хэрэгжилтийг тооцох бол Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр 29.7%-тай, аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөр 34.0%-тай хэрэгжсэн болно.

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ ХИЙЖ, ТАЙЛАН ГАРГАСАН:

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ

ТАСГИЙН ДАРГА

МЭРГЭЖИЛТЭН

Г. ХАНДАРМАА

Ч. СҮРЭНХОРОЛ

В. ОТГОНБАТ

ХЯНАСАН

ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

Б.ТҮВШИНБАЯР

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2009 ОНЫ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2010 оны 03 сарын 23-ны өдөр

Аймгийн Засаг даргын 2009 оны 33 тоот захирамжаар батлагдсан “Хяналт шинжилгээ, үнэлгээний” тасаг Монгол улсын Засгийн газрын 2010 оны 11 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргаас батлагдсан удирдамжийн дагуу 2009 оны 03 сарын 15-ны өдрөөс 14 хоногийн хугацаанд аймгийн Засаг даргын Тамгын газрын 2009 оны үйл ажиллагааны гүйцэтгэлд хяналт шинжилгээ хийлээ

Хяналт шинжилгээ үнэлгээний ажлыг гүйцэтгэхдээ аймгийн Засаг даргын Тамгын газрын мэргэжилтнүүдтэй биечлэн уулзаж үйл ажиллагаатай нь танилцах, 2009 оны ажлын гүйцэтгэлийг гаргасан баримт бичгийг судлах, түүнд хяналт шинжилгээ хийх журмаар ажилласан болно

Нэг. Байгууллагын үйл ажиллагааны талаар

Аймгийн Засаг даргын Тамгын газар нь өнгөрсөн 2009 онд Монгол Улсын Засгийн газрын болон аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах, төр засгийн бодлого, хууль, тогтоол шийдвэрийг мөрдүүлэх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарсан заавар, зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх, төрийн албаны стандартыг хангуулах, ажилтан албан хаагчдын мэдлэг боловсролыг дээшлүүлэх, хөгжүүлэх, төрийн үйлчилгээг иргэдэд тасралтгүй, чанартай шуурхай хүргэж, төрийн албаны мэргэшсэн чадварлаг аппаратыг бүрдүүлэн ажиллахад гол анхаарлаа хандуулан ажилласан байна

Тус байгууллага нь Монгол улсын Засгийн газрын 2008 оны 67 дугаар тогтоолоор баталсан орон тоо бүтцийн жишгийн дагуу 5 хэлтэс, 1 штабын зохион байгуулалттай, 38 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулж байна.

Байгууллагын албан хаагчдын 62.1 хувь нь дээд, 8.1 хувь нь тусгай дунд боловсролтой, 29.7 хувь нь магистр байна. Албан хаагчдыг бүтцээр нь авч үзвэл эрэгтэй 11, эмэгтэй 26 хүн, насны хувьд 20-25 настай 6, 26-35 настай 8, 36-45 настай 11, 46-55 настай 12, дундаж нас 35 байна. Мэргэжлийн хувьд эдийн засагч, нягтлан бодогч 13, багш 5, эрх зүйч 4, инженер 3, хуульч 2, гадаад харилцааны мэргэжилтэн 1 бусад мэргэжлийн 8 хүн байгаа ба эдгээрээс төрийн албанд 1-5 жил ажилласан 13, 6-10 жил

ажилласан 4, 11-15 жил ажилласан 3, 16-20 жил ажилласан 9, 20 ба түүнээс дээш жил ажилласан 9 хүн байна.

Ажилтан албан хаагчдын ажиллах ая тухтай нөхцлийг нэмэгдүүлэх зорилгоор компьютер техник тоног төхөөрөмжийн шинэчлэл хийж аймгийн Засаг даргын Тамгын газарт “Угтах үйлчилгээ”-г нээн ажиллуулж байгаа нь ажилтан албан хаагчдын ажиллах ая тухтай орчин нөхцлийг бүрдүүлсэн төдийгүй иргэдэд хүргэх төрийн үйлчилгээг нэг цэгээс хүргэх орчинг бүрдүүлсэн шинэ ололт хөгжил болсон байна.

Байгууллагын ерөнхий менежер эрхлэх асуудлын хүрээнд төсвийн ерөнхийлөн захирагчтай, нэгжийн менежер /хэлтсийн дарга /-үүд байгууллагын ерөнхий менежертэй, төрийн албан хаагчид нэгжийн менежерүүдтэй үр дүнгийн гэрээ байгуулан ажилласан байна. Үр дүнгийн гэрээний хэрэгжилтийг улирал бүр хэлэлцэж холбогдох арга хэмжээг авч ажилласаны зэрэгцээ бүтэн жилээр дүгнэж, жилийн эцэст байгууллагын үйл ажиллагааны тайланг аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн “Дүүрэн хангалттай” буюу 90% гэсэн үнэлгээг авсан байна.

Аймгийн Засаг даргын зөвлөл 14 удаа хуралдаж цаг үеийн шинж чанартай буюу Засаг даргаас бие даан шийдвэрлэх боломжгүй арга хэмжээнүүдийг авч хэлэлцэн нийт 73 шийдвэрийг гаргасан байна. Түүнчлэн хэлтсийн дарга нарын зөвлөгөөнийг 60 удаа зохион байгуулж цаг үеийн ажлыг хэлэлцэн шийдвэр гаргаж ажилласан байна.

2009 онд аймгийн Засаг даргын захирамж 786, Тамгын газрын даргын тушаал 164-ийг гаргасан байгаа бөгөөд иргэд хөдөлмөрчдөөс Аймгийн Засаг дарга, Тамгын газарт хандан 309 өргөдөл хүсэлт ирснээс 289 өргөдлийг хуулийн хугацаанд нь бүрэн шийдвэрлэж, шийдвэрлэлт 93,5%-тай байна.

Хоёр. Ажилд гарч буй ололт, амжилтын талаар

2.1 Эдийн засгийн бодлогын хүрээнд

Хэдийгээр улс орны хэмжээнд санхүүгийн хямралтай байсан хэдий ч аймгийн эдийн засагт бодит ахиц дэвшил бий болж, 10 гаруй тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтын ажлыг хийж амжуулсаны зэрэгцээ ядуурлыг бууруулах ажилгүйдлийг багасгах бодлогоо амжилттай хэрэгжүүлж 1008 шинэ ажлын байрыг бий болгосон амжилт дүүрэн байгаа нь орон нутгийн төр захиргааны байгууллагын бодлого үйл ажиллагаа зөв явж байгаатай нягт холбоотой байна

2009 онд орон нутгийн төсөвт 22736.9 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 24884.8 сая төгрөг төвлөрүүлж, орлогын төлөвлөгөө 2147.9 сая төгрөгөөр буюу 9.4 хувиар давж

биелэгдсэн ба өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 11.2 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

2009 онд орлогын төлөвлөгөө нэр төрлөөрөө давж биелэгдлээ.

Давсан орлогыг орлогын төрлөөр авч үзвэл:

-Орлогын албан татварын орлого 16.8 хувиар буюу 267.4 сая төгрөгөөр

-Өмчийн татвар 34.1 хувиар буюу 47.7 сая төгрөгөөр

-Авто болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар 9.2 хувиар буюу 42.2 сая төгрөгөөр

-Бусад татварын орлого 14.1 хувиар буюу 1557.5 сая төгрөгөөр

-Татварын бус орлого 2.4 хувиар буюу 229.5 сая төгрөгөөр

-Хөрөнгийн орлого 6.0 хувиар буюу 3.8 сая төгрөгөөр тус тус давж биелэгдсэн байна.

2009 онд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлого 23.0 хувиар буюу 1492.6 сая төгрөгөөр, Хувьцааны ногдол ашиг 1.6 хувиар буюу 146.5 сая төгрөгөөр давж биелсэн ба лицензийн төлбөрийн орлого 100.0 хувь биелэгдсэн байна.

Орон нутгийн төсвийн орлогын дүнд ашигт малтмалын нөөцийн төлбөр 32.1, хувьцааны ногдол ашиг 36.3, лицензийн төлбөрийн орлого 15.4, бусад орлого 16.2 хувийг эзэлж байгаа ба нийт орлогын 83.8 хувийг уул уурхайн салбар эзэлж байна.

Аймгийн өөрийгөө санхүүжүүлэх чадавхи 181.1 хувьд хүрч, өнгөрсөн оноос нэмэгдсэн байна.

2009 онд орон нутгийн төсвөөс улсын төсөвт 10552.0 сая төгрөг төвлөрүүлэхээс 100.0 хувь төвлөрүүлж, төсвийн өмнө хүлээсэн үүргээ бүрэн биелүүлсэн байна.

Төсвийн зарлага санхүүжилтэнд 12614.3 сая төгрөг зарцуулахаас 13742.9 сая төгрөг зарцуулж, төсөвт зардал 1128.9 сая төгрөгөөр буюу 8.9 хувиар хэтэрсэн байна.

Орон нутгийн төсвийн орлого нэмэгдэхийн хирээр аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөр, аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан арга хэмжээ, хөрөнгө оруулалт, их засварын ажлыг гүйцэтгэж ирсэн байна. Тухайлбал: 2008 онд 5100.0 сая төгрөг, 2009 онд 4021.4 сая төгрөг зарцуулсан байна. Мөн аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан эрүүл мэнд, боловсрол, соёл шинжлэх ухаан, нийгмийн хөгжил болон төрийн захиргаа, эрх зүйн шинэчлэлийн асуудлыг хэрэгжүүлэхэд 2009 онд 6696.2 сая төгрөг зарцуулсан байна.

Аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрт заагдсан “Нутгийн хишиг” хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэний зэрэгцээ “Оюу толгой” төслийн хөрөнгө оруулалтын гэрээ

батлагдан, уул уурхайг дагасан их хөгжлийн эх тавигдаж ажлын байр нэмэгдэн, орон нутгийн хөгжилд уул уурхайн үйлдвэрлэлээс үзүүлэх нөлөөлөл ихэссэн байна.

Аймгийн Засаг даргын Тамгын газраас “Байгалын баялаг-Сайн засаглал-Хөгжсөн Өмнөговь” нэртэй хөгжлийн төлөвлөгөөг боловсруулан гаргаж Монгол улсын хөгжлийн “Жишиг аймаг” болох зорилт тавин ажиллаж эхэлжээ.

Тус аймгийн нутгаар БНХАУ-тай харилцдаг хилийн 2 боомтыг байнгын ажиллагаатай болгосоноор иргэд, бизнес эрхлэгчдийн худалдаа хийх нөхцөл сайжран, гадаад худалдааны эдийн засгийн үр ашиг дээшилж байгаа нь статистик тоо баримтаас харагдаж байна.

2,2 Төрийн захиргааны бодлогын хүрээнд

Засгийн газрын үйл ажиллагааны төлөвлөгөөнд аймгийн Засаг даргаас холбогдох яамдтай хамтран хэрэгжүүлэхээр заагдсан заалтуудын хэрэгжилт, Өмнөговь аймгийг 2005-2008 онд хөгжүүлэх Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар дорвитой анхаарч хэрэгжилтийн явц байдлыг улирал бүр гарган хяналт шинжилгээ хийж, хагас бүтэн жилээр аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар авч хэлэлцэн холбогдох арга хэмжээг тухай бүр нь авч хэрэгжүүлэн ажиллаж ирсэн байна. Аймгийн Засаг даргаас бүрэн эрхийн хугацааны 365 хоногийн ажлын тайлангаа иргэдэд орон нутгийн радио телевиз, сонин хэвлэлээр сурталчилсаны зэрэгцээ өнгөрч байгаа 1 жилд хийсэн хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтын ажил, олсон ололт амжилтаа харуулсан ном хэвлэн гаргаж аймгийн хэмжээний бүх сум баг, иргэдэд хүргэж хийсэн ажлаа тайлагнасан байна.

Төрийн албан хаагчдыг ажлын байрандаа суралцах нөхцөл бололцоог бүрдүүлэх, хэрэгцээт мэдээллээр хангаж, сургаж хөгжүүлэх зорилгоор, мэргэжлийн багш нартай хамтран шат дараалсан сургалтуудыг орон нутагтаа зохион байгуулж, төрийн албан хаагчдын туршлага солилцох уулзалт сургалтыг бүсчлэн сумдад зохион байгуулсан нь сумдад ажиллаж байгаа төрийн албан хаагчдын талархалыг хүлээсэн ажил болсон байна. Төрийн албан хаагчдын гадаад хэлний мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор АНУ-аас мэргэжилтэн багш урьж ирүүлэн төрийн албан хаагчдад англи хэлний сургалтыг 2 үе шаттайгаар зохион байгуулж энэхүү сургалтанд аймгийн ЗДТГазрын нийт 18 төрийн албан хаагч хамрагдаж байна.

Төрийн жинхэнэ албан хаагчдыг мэргэшүүлэх чиглэлээр 2009 онд Удирдлагын Академид 22 хүнийг сургасаны дээр гадаадын зарим оронд тухайлбал: Тайланд,

БНХАУ, АНУ, Солонгос, Япон, Герман зэрэг орнуудад төрийн албан хаагчдыг мэргэжил дээшлүүлэх, туршлага судлуулах, мэргэшүүлэх сургалт семинаруудад үе шаттайгаар хамруулсан байна.

Засгийн газар болон аймаг орон нутгийн удирдлагаас авч хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны хөтөлбөрүүдийн хэрэгжилт, хийсэн ажлын тайлан үр дүнг ард иргэдэд сурталчилан таниулах, сумдын цаг үеийн ажил, өвөлжилт хаваржилтийн байдалтай газар дээр нь үзэж танилцах, заавар зөвлөмжөөр хангах, дэмжлэг туслалцаа үзүүлэх, иргэдийн санал бодлыг сонсох, шаардлагатай зарим арга хэмжээг газар дээр нь авч хэрэгжүүлэх зорилгоор аймгийн Засаг даргын Тамгын газар, хэлтэс агентлагуудаас хамтарч сумдын ажилд хяналт шинжилгээ хийж үнэлэлт дүгнэлт өгөх, зөвлөн туслах ажлыг 2009 оны 05, 11 саруудад 2 удаа зохион байгуулж, багуудын хурал өдөрлөгүүдэд оролцож ажилласан нь төрийн үйлчилгээг иргэдэд ойртуулсан, орон нутгийн удирдлагын шийдвэрт иргэдийн санаа бодлыг тусгах боломжыг бүрдүүлсэн үр дүнтэй ажил болсон байна.

Төрийн албаны хөнгөн шуурхай байдлыг бий болгох, мэдээллээр түргэн шуурхай хангаж байх үүднээс Өмнөговь аймгийн вэб хуудсыг Засгийн газрын Вэб сайтад байрлуулж, аймгийн Засаг даргын Тамгын газар болон Нутгийн удирдлагын ордонд байрлаж байгаа агентлагуудыг удирдлагын электрон системд холбож, албан хаагчдын цаг бүртгэлийг хурууны хээгээр авч байгаа нь байгууллагын хөгжлийг орчин үеийн хөгжил дэвшилд ойртуулсан төдийгүй албан хаагчдын ажлын цагийг хэмнэсэн, үргүй зардлыг багасгасан үр дүнтэй ажил болсон байна.

Засаг захиргааны анхан шатны нэгж болсон багийн хөгжлийг орон нутгийн удирдлагаас дэмжих, Монгол улсын Засгийн газраас багийн хөгжлийн талаар баримталж байгаа үүрэг чиглэлийн дагуу орон нутагт аймгийн дэд хөтөлбөр гарган хэрэгжүүлж түүний хүрээнд 2009 онд хийх ажлын төлөвлөгөөг гарган аймгийн Засаг даргын 232 тоот захирамжаар батлан хэрэгжүүлж ажилласан төдийгүй хөтөлбөрийн хүрээнд орон нутгийн төсөв болон хандив тусламжийн хүрээнд 250,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийж 1 багийн төвийг шинээр барьж, 7 багийн төвийг засварласан зэрэг томоохон хэмжээний хөрөнгө оруулалтыг хийсэн байна.

2,3 Нийгмийн бодлогын хүрээнд

Төрийн байгууллага түүнд ажиллаж байгаа албан хаагчдыг чадваржуулах, мэргэжилтэй боловсон хүчний хүрэлцээ хангамжыг нэмэгдүүлэхэд чиглэсэн оновчтой бодлого баримтлан, ойрын 3 жилийн хугацаанд хэрэгцээ шаардлагатай мэргэжилтний

судалгааг гаргаж түүнд тулгуурлан их дээд сургуульд хэрэгцээт мэргэжлээр суралцаж байгаа оюутан сурагчидтай гэрээ байгуулах, орон нутгийн захиалгаар холбогдох сургуулиудад оюутан элсүүлж суралцуулах, мэргэжилтэй боловсон хүчнийг мэргэжил дээшлүүлэх мэргэшүүлэх сургалтуудад үе шаттайгаар хамруулах зэрэг олон ажлуудыг төлөвлөн “Оюу толгой” төсөлтэй хамтран ажиллаж байна.

Ажлын байрыг нэмэгдүүлэх үүднээс орон нутгийн аж ахуйн нэгж, байгууллагуудын үйл ажиллагааг дэмжиж тэдэнтэй хамтран ажилласнаар 2009 онд 370 иргэдийг ажил мэргэжлийн сургалтанд хамруулж, 1342 иргэнийг ажлын байранд зуучилж, ажлын байр нэмэгдүүлэх хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн зээлээр 240 шинэ ажлын байр, нийтдээ 2009 онд 1008 шинэ ажлын байр бий болгосон байна.

Аймаг орон нутгийн хөгжлийн гол бодлогыг тодорхойлж, хэрэгжүүлэгч болохын хувьд аймгийн ИТХ, Засаг даргын Тамгын газраас нийгмийн салбарын байгууллагуудын хөгжлийг хангах “Боловсролыг хөгжүүлэх мастер төлөвлөгөө”, “Хүмүүнлэгийн хөтөлбөр”, “Нутгийн хишиг” хөтөлбөр, “Ажилгүйдэл ядуурлыг бууруулах хөтөлбөр” зэрэг 20 гаруй хөтөлбөр төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж байна.

Гурав. Үйл ажиллагааны явц үр дүнгийн талаар

3.1 Бодлогын зорилтын хэрэгжилтийн явц үр дүнгийн талаар

Монгол улсын Засгийн газраас батлан гаргаж байгаа үндэсний хөтөлбөр, тогтоол шийдвэр, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөр болон, байгууллагын алс хэтийн болон цаг үеийн үйл ажиллагааны төлөвлөгөөтэй нягт уялдуулан хэрэгжүүлж байгаа нь төрийн бодлого шийдвэрийг орон нутагт амжилттай хэрэгжүүлэх чухал алхам болж байна. Мөн түүнчлэн аймаг орон нутгийг хөгжүүлэх бодлогын гол баримт бичиг болох “Байгалийн баялаг”сайн засаглал-хөгжсөн Өмнөговь” хөтөлбөр, “Ажилгүйдэл ядуурлыг бууруулах аймгийн дунд хугацааны хөтөлбөр”, баруун бүсийн хөгжлийн мастер төлөвлөгөө, байгаль орчны суурь судалгаа зэрэг томоохон хэмжээний хөтөлбөрүүдийг боловсруулан хэрэгжүүлж, орон нутгийг хөгжүүлэх, ажилгүйдэл ядуурлыг бууруулах, хүн амын амьжиргааг өсөн нэмэгдүүлэх олон талт арга хэмжээг төр засгийн бодлого шийдвэртэй уялдуулан зохион байгуулж ажилласан нь чухал үр дүнтэй ажил болжээ.

3.1.1 Үндэсний хөгжлийн цогц бодлогын хэрэгжилт

Монгол улсын Их Хурлын 2008 оны 12 дугаар тогтоолоор баталсан “Үндэсний хөгжлийн цогц бодлого”-д заасан стратегийн зорилтуудаас эхний үе шатанд хэрэгжих

зорилтуудыг хяналтанд авсан байна. Монгол улсын мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогод тусгагдсан стратегийн зорилтуудаас орон нутгийн удирдлагаас хамтран хэрэгжүүлэхээр 6 тэргүүлэх чиглэлийн хүрээнд тусгагдсан 119 стратегийн зорилтыг түүвэрлэн авч, хэрэгжилтийг тооцсон байна. Монгол улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр болон аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрт 122 заалт, аймгийн эдийн засаг нийгмийг 2009 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд 94 заалт тусган хэрэгжүүлж ажилласан байна

Үндэсний хөгжлийн цогц бодлогын хэрэгжилтийг Монгол улсын Засгийн газрын 2010 оны 11 дүгээр тогтоолын дагуу үнэлгээ өгч үзэхэд 2009 оны жилийн эцсийн байдлаар 20,1 хувьтай, тухайн жилд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний хэрэгжилт нь дунджаар 85,7%-тай хэрэгжсэн байна.

2009 онд аймгийн Засаг даргын Тамгын газраас Өмнөговь аймгийг 2009-2021 онд хөгжүүлэх “Байгалийн баялаг-сайн засаглал- хөгжсөн Өмнөговь” хөгжлийн хөтөлбөрийг боловсруулж ажиллаж байгаа бөгөөд энэхүү хөтөлбөр нь үндэсний хөгжлийн цогц бодлогын хөтөлбөрт үндэслэн боловсруулагдсан хөтөлбөр байна.

3.1.2 Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт

Монгол улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд орон нутгийн удирдлагаас хамтран хэрэгжүүлэхээр заагдсан 94 зорилтын хүрээнд багтах 174 заалтыг хяналтанд авч, тусгай төлөвлөгөө гарган эзэнжүүлж хэрэгжилтийг тооцож ажиллаж байна.

Хөтөлбөрийн хэрэгжилтийг Монгол улсын Засгийн газрын 2010 оны 11 дүгээр тогтоолын дагуу үнэлгээ өгч үзэхэд 2009 оны жилийн эцсийн байдлаар дунджаар 29,5%-тай хэрэгжиж байна.

Хүн ам нийгмийн зохистой бодлогыг хэрэгжүүлснээр иргэдийн амьдралын чанарыг сайжруулах зорилтын хүрээнд төлөвлөгдсөн 58 заалт дунджаар 28,1%-тай, үйлдвэржүүлэлтийн бодлогыг хэрэгжүүлснээр эдийн засгийн өсөлт, тогтвортой байдлыг хангах зорилтын хүрээнд төлөвлөгдсөн 66 заалт арга хэмжээ дунджаар 25,5%, байгаль орчны тэнцвэрт харьцааг хангах зорилтын хүрээнд төлөвлөгдсөн 25 арга хэмжээ дунджаар 24,9%-тай, эрх зүйт төрийг төлөвшүүлж, засаглалын үйл ажиллагааг ил тод нээлттэй болгох, улс орныг батлан хамгаалах, гадаад бодлогын зорилтын хүрээнд төлөвлөгдсөн 25 арга хэмжээ дунджаар 36,5%-тай хэрэгжиж байна.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд гарч байгаа ололттой тал нь орон нутгийн удирдлагаас хамтран хэрэгжүүлэхээр заагдсан заалтуудын хэрэгжилтийг түүвэрлэн хяналтанд авч, эзэнжүүлсэн, хэрэгжилтийн явц байдлыг улирал бүр тооцож, хяналт тавьж байгаа, хэрэгжилтийн явц байдал болон, гарах үр дүнг тусад нь тооцож байгаа нь үр дүнг эрхэмлэсэн чухал шалгуур үзүүлэлт болсон байна

Гэсэн хэдий ч тус хөтөлбөр нь голдуу дээд түвшний байгууллагаас санаачлан хийхээр үйл ажиллагаанууд тусгагдсан байгаагаас орон нутгаас ямар үйл ажиллагааг хийх нь зарим заалтын хувьд тодорхой бус байгаа, холбогдох бодлогын мэргэжилтнүүдээс хэрэгжилтийг тооцож гаргахдаа, үнэлгээ буруу өгөх, үр дүнгээ тооцож чадахгүй байх явдал цөөнгүй гарсан байна.

3,1,3 Үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилт

2009 оны жилийн эцсийн байдлаар Монгол Улсын Их Хурлын тогтоолоор баталсан 2, Засгийн Газрын тогтоолоор баталсан 58 үндэсний хөтөлбөрийг хяналтанд авч, хэрэгжилтийг тооцон ажиллаж байна. Хөтөлбөрийн хэрэгжилтийг Засгийн газрын 2010 оны 11 дүгээр тогтоолоор дүгнэж үзэхэд 90%-тай хэрэгжиж байгаа – 15, 70%-тай хэрэгжиж байгаа 30, 50%-тай хэрэгжиж байгаа 14, 30%-тай хэрэгжиж байгаа 4, 10%-тай хэрэгжиж байгаа 1 хөтөлбөр байна. Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг 2009 оны жилийн эцсийн байдлаар дүгнэж үзэхэд 80,0%-тай хэрэгжиж байна. Дээрхи үндэсний хөтөлбөрийг орон нутагт амжилттай хэрэгжүүлэхэд анхаарч орон нутгийн онцлог байдалд тохируулан 31 дэд хөтөлбөр, 10 стратеги төлөвлөгөөг аймгийн ИТХурал болон ИТХТ-ийн хурлаас батлан хэрэгжүүлж ажиллаж байна. Ингэснээр үндэсний хөтөлбөрүүд амжилттай хэрэгжих боломж нэмэгдэж байгаа бөгөөд орон нутгийн төсвөөс дэд хөтөлбөр төлөвлөгөөг санхүүжүүлэхэд өнгөрсөн 2009 онд 280,0 сая төгрөгийг зарцуулсан байна.

Үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг Засгийн газрын 2009 оны 285 дугаар тогтоолоор баталсан журам аргачлалын дагуу хэрэгжилтийг тооцож ажиллаж байна.

3,2. Бодлогын зорилтын хэрэгжилтийн зохицуулалтын талаар

3,2,1 Үндсэн чиглэлийн хэрэгжилт

Монгол улсын эдийн засаг нийгмийг хөгжүүлэх 2009 оны үндсэн чиглэлийн хүрээнд аймгийн Засаг даргаас хамтран хэрэгжүүлэх үйл ажиллагааны заалтыг тусгайлан хяналтандаа авч хэрэгжилтийг улирал бүр тооцож ажилласаны зэрэгцээ Монгол улсын эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд аймаг орон нутгаас хамааралтайгаар хэрэгжүүлэх асуудлуудыг судлан аймгийн нийгэм эдийн засгийг

хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгаж ажилласан байна. Төлөвлөгөөний хэрэгжилтийг Засгийн газрын 2010 оны 11 дүгээр тогтоолын дагуу дүгнэж үзэхэд 76,8%-тай хэрэгжжээ.

Засгийн газрын үндсэн чиглэлд тусгагдсан асуудлуудыг аймгийн үндсэн чиглэлд давхар тусган хэрэгжүүлж ажилласанаар үндсэн чиглэлийг хэрэгжүүлэхэд 2009 онд орон нутгийн төсвөөс 1571,0 сая төгрөгийг зарцуулсан байна.

Аймаг орон нутгаас хамаарахгүй улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх байсан зарим ажил үйлчилгээнүүд хийгдээгүйгээс үндсэн чиглэлийн хэрэгжилт төлөвлөсөн хэмжээнээс доогуур гарсан байна.

3,2,2 Батламжийн хэрэгжилт

Мөн аймгийн Засаг даргаас Монгол улсын Ерөнхий сайдтай байгуулсан батламжын хэрэгжилтийг хагас бүтэн жилээр тооцож, тайланг үнэлгээний хамт Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлж ажилласан байна. Батламжын хэрэгжилтийг дүгнэж үзэхэд 96,8%-тай хэрэгжүүлсэн байна.

3,2,3 Засаг даргын мөрийн хөтөлбөрийн биелэлт

Өмнөговь аймгийг 2009 -2012 онд хөгжүүлэх Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр нь 16 бүлэг зорилтын хүрээнд багтах 176 заалттай хэрэгжүүлж ажилласан бөгөөд хэрэгжилтийг 51 дүгээр тогтоолын дагуу улирал бүр тооцож, дүн мэдээг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хагас бүтэн жилээр хүргүүлж ажилласан байна. Хөтөлбөрийн хэрэгжилтийг авч үзвэл хэрэгжүүлбэл зохих нийт 176 заалтаас 100 хувь бүрэн хэрэгжсэн -1, 81-99 хувьтай хэрэгжиж байгаа -6, 61-80 хувьтай хэрэгжиж байгаа 6, 41-60 хувьтай хэрэгжиж байгаа -22, 21-40 хувьтай хэрэгжиж байгаа 126, 5-20 хувьтай хэрэгжиж байгаа 15 заалт байгаа бөгөөд хөтөлбөрийн хүрээнд тавьсан зорилт үйл ажиллагаа дунджаар 34,01 хувийн биелэлттэй, хөтөлбөрийн хүрээнд тухайн жилд хийхээр төлөвлөсөн ажил 92,04 хувьтай хэрэгжсэн байна. Мөн мөрийн хөтөлбөрийг хэрэгжилтэд улирал бүр хяналт шинжилгээ хийж дүн мэдээг аймгийн Засаг даргад хүргүүлж ажилласаны зэрэгцээ хагас бүтэн жилээр аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулж холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлж ажиллажээ. Мөн мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг тусгайлан гаргаж үйл ажиллагааны жил жилийн хүрэх түвшин шалгуур үзүүлэлтийг тодорхой болгож өгсөн нь мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтийг дүгнэж үнэлгээ өгөхөд нэлээд амар хялбар болсон байна. 2009 оны 11 сард аймгийн Засаг даргаас мөрийн хөтөлбөрийн хүрээнд өнгөрсөн нэг жилийн

хугацаанд хийсэн ажлаа “Бүрэн эрхийн хугацааны 365 хоног” нэртэйгээр аймаг орон нутгийн радио телевиз сонин хэвлэлээр тайлагнаж жижиг хэмжээний ном болгон хэвлэн гаргасан байна.

3.2.4 Тогтоол шийдвэрийн хэрэгжилт

Засгийн газрын тогтоол шийдвэрийн 2009 онд нийт 84 шийдвэрийн 114 заалтыг хяналтад авч ажилласан нь 89 хувийн биелэлттэй байна. Үүнээс засгийн газрын тогтоол 88,4 хувь, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл 76 хувь, засгийн газрын албан даалгавар 93,3 хувь, шадар сайдын тушаал 95 хувь биелсэн байна. Засгийн газрын тогтоолын 27,3 хувийг бүрэн биелж, 63,2 хувь нь хэрэгжих шатандаа, 0,6 хувь нь биелэлтийг тооцох хугацаа болоогүй, зохион байгуулалтаас хурлын тэмдэглэлийн 1 заалт тасарсан байна.

Засгийн газар болон холбогдох дээд шатны байгууллагаас ирүүлж байгаа хөтөлбөр тогтоол, албан даалгавар, дүрэм журмуудын хэрэгжилтийг орон нутаг чанартай зохион байгуулах үр дүнд хүргэхэд онцгойлон анхаарч төрийн албан хаагчдын сургалт уулзалт, сумдын Тамгын газрын мэргэжилтнүүдэд зохион байгуулсан сургалт семинаруудад хөтөлбөр тогтоолын хэрэгжилт тооцож мэдээлэх талаар тусгай хичээл бэлтгэн сургалт явуулсан нь тодорхой үр дүнд хүрсэн байна. Мөн хяналтанд авах хөтөлбөр тогтоолын жагсаалтыг гаргаж бүх хэлтэс байгууллага сумдад хүргүүлэн, 2010 онд Засгийн газрын тогтоол шийдвэр, үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилт тавин ажиллаж, байгууллагын албан хаагчдын үр дүнгийн гэрээнд тусгай захиалгат бүтээгдэхүүн болгон оруулж, хэрэгжилтийг улирал бүр тооцож байхаар тусгаад ажиллаж байна

Төсвийн ерөнхийлөн захирагчаас ерөнхий менежертэй нийт нийлүүлэх 28, тусгай захиалгат-8 бүтээгдэхүүнийг нийлүүлэхээр үр дүнгийн гэрээ байгуулан ажилласан байна. Үр дүнгийн гэрээг 90,0 хувиар биелүүлж ажилласан байна.

3.3. Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлын талаар

Монгол улсын Засгийн газрын 2009 оны 143 дугаар тогтоолоор баталсан “Ил тод байдлын шалгуур үзүүлэлт”-ийг хяналтанд авч, Засаг даргын Тамгын газрын даргын 2009 оны 07 сарын 22-ны 2-955 дугаар тоотоор аймгийн Засаг даргын дэргэдэх агентлаг, төсөвт байгууллага, бүх сумдад уг тогтоолыг бүрэн эхээр нь хүргүүлж ил тод байдлын шалгуур үзүүлэлтийг хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган байгууллага бүр өөр

өөрийн түвшинд тогтоолыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахыг даалгасан байна. Мөн энэ үүрэг чиглэл өгсөний хүрээнд 11 сард бүх сум байгууллагын ажилд ил тод байдлын шалгуур үзүүлэлтийг хэрхэн хэрэгжүүлж байгаад хяналт шалгалт хийж, үүрэг чиглэл өгч ажилласан байна.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын түвшинд 143 дугаар тогтоол гарсантай холбогдуулан “Угтах үйлчилгээ”-г бий болгож, угтах үйлчилгээг ажиллуулах журамд байгууллагын ил тод байдлын шалгуур үзүүлэлтийг хангаж ажиллах талаар 6 заалт тусгасан байна. Энэхүү журмын хүрээнд Аймгийн Засаг даргын Тамгын газарт ажиллаж байгаа “Угтах үйлчилгээ”-нд “Төрийн үйлчилгээ авахтай холбоотой материалын жагсаалт”, “Байгууллагын үйл ажиллагаанд дагаж мөрдөж байгаа хууль тогтоомж дүрэм журам” зэргийг электрон хэлбэрээр байршуулан иргэдэд үйлчилгээ үзүүлж байна. Мөн аймгийн Засаг даргын Тамгын газрын үүдэнд дэлгэц байрлуулан тухайн өдөр тухайн байгууллага дээр зохион байгуулагдах ажил үйлчилгээ, мэдээ мэдээллийг тогтмол гаргаж иргэдэд мэдээлэл хүргэж байна. Түүнчлэн аймгийн Засаг даргын Тамгын газраас ямар ажил зохион байгуулсан талаарх мэдээллийг аймгийн вэб сайт, орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр сар бүр сурталчилж ажиллаж байна. Хүний нөөцийн ил тод байдлын шалгуур үзүүлэлтийг хангаж ажиллах талаар хийх ажлуудыг 2010 онд хийхээр төлөвлөн ажиллаж байна.

Төсөв санхүү болон худалдан авах ажиллагааг тухай бүр нь орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, байгууллагын дотоод сүлжээ, вэб сайтаар сурталчилж хэвшүүлж байгаа төдийгүй төсөв санхүүгийн болон төрийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагаанд иргэний нийгмийн байгууллагын төлөөллийг татан оролцуулж үйл ажиллагааны ил тод нээлттэй байдлыг нэмэгдүүлсэн байна.

Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлын хүрээнд төлөвлөгдсөн шалгуур үзүүлэлт дунджаар 93.3 хувьтай, хүний нөөцийн бодлогын ил тод байдлын шалгуур үзүүлэлт 80.6 хувьтай, төсөв санхүүгийн ил тод байдлын шалгуур үзүүлэлт 93.6 хувьтай, төрийн болон орон нутгийн өмчөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдлын шалгуур үзүүлэлт дунджаар 86 хувьтай хэрэгжсэн байна.

3.4. Үйл ажиллагааны үр нөлөө, үр дагаварын талаар

3.4.1. Хэрэглэгчийн судалгаа

Монгол улсын Засгийн газрын 2006 оны 51 дүгээр тогтоолын дагуу төрийн бодлого шийдвэр иргэдийн амьдралд ямар өөрчлөлт гаргасаныг судлан тогтоох

зорилгоор хэрэглэгчийн үнэлгээг аймгийн хэмжээнд ажиллаж байгаа Иргэний нийгмийн байгууллагын сүлжээний хамт олноор гэрээгээр гүйцэтгүүлсэн байна. Тус иргэний нийгмийн байгууллага нь аймгийн хэмжээний бүх сум багийг хамруулан нийт 2500 хүнээс судалгааг тусгайлан боловсруулсан саналын хуудсаар авч дүн мэдээг нэгтгэн аймгийн ЗДТГазарт ирүүлсэн байна. Хэрэглэгчдийн үнэлгээгээр аймаг сумдын хэмжээнд үзүүлж байгаа төрийн үйлчилгээнд 3,42 гэсэн оноог өгсөн байгаа нь хэрэглэгчийн сэтгэл ханамж 2008 оноос 0,02 хувиар өссөн үзүүлэлт гарсан байна.

“Та нэн түрүүнд төрийн ямар үйлчилгээг хүсэж байна вэ” гэсэн асуултанд судалгаанд оролцогчдын 80 хувь нь буюу 2000 иргэн хариулт өгсөн байгаа бөгөөд тэдгээрийн 31% нь намуудын сонгуулиар амласан мөнгө төгрөгийг бэлнээр авах, 22% нь хөнгөлөлттэй зээл тусламжид хамрагдах, малжуулах төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх, 28% нь ажлын байрыг нэмэгдүүлэх, 14% нь цалин хөлсийг нэмэгдүүлэх, үлдсэн 5 хувь нь өөр бусад үйлчилгээг авахыг хүсэж байгаагаа илэрхийлсэн байна.

Санал асуулгын дүнгээр аймгийн хэмжээнд хууль тогтоомж Засгийн газрын шийдвэрийн биелэлт – 3,36, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт – 3,34, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт – 3,44, аймаг сумдын Засаг дарга нараас иргэдэд үзүүлж буй үйлчилгээ – 3,56 буюу нийт үнэлгээгээр 3,42 гэсэн үнэлгээг авсан байна.

Аймгийн Засаг даргын Тамгын газар нь Засгийн газрын болон аймаг орон нутгийн бодлого шийдвэрийг амжилттай хэрэгжүүлж ажиллаж байгаагийн зэрэгцээ хугацаатай тайлан мэдээ, хариутай бичгийн хариу, ирсэн өргөдөл гомдлыг цаг хугацаанд нь бүрэн шийдвэрлэж ажилласан байна. 2009 онд аймгийн Засаг даргын нэр дээр болон аймгийн ЗДТГазарт нийт 3209 албан бичиг тоот ирсэнээс 344 нь хариутай бичиг байгаагаас 336 бичгийг хуулийн хугацаанд шийдвэрлэсэн байгаа бөгөөд 1 бичгийг хугацаа хоцруулан шийдвэрлэж, 6 албан бичиг шийдвэрлэх хугацаа болоогүй байна.

Тус байгууллага нь 2009 онд дэвшүүлсэн зорилтуудаа амжилттай хэрэгжүүлж, орон нутагт бодлого шийдвэрээ зөв тодорхойлон амжилттай ажиллаж байна гэж дүгнэж байна.

Хяналт шинжилгээ, үнэлгээний дүнг үндэслэн ажлын хэсгийн зүгээс:

Засгийн 2009 оны 143 дугаар тогтоолоор баталсан “Ил тод байдлын шалгуур үзүүлэлт”-ийг ханган биелүүлэх ажлыг эрчимжүүлэх

Байгууллагын стратеги төлөвлөгөөг шинэчлэн, Засгийн газрын болон аймаг орон нутгийн түвшинд гарч байгаа бодлогын баримт бичгүүдтэй уялдуулан боловсруулах.

Ажилтан албан хаагчдын ажлын уялдаа холбоо, багаар ажиллах чадварыг сайжруулах

Байгууллагын хэлтэс тасгийн ажилд хагас бүтэн жилд хяналт шинжилгээ хийж, удирдлагыг байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэдээ мэдээллээр хангаж ажиллах

УИХурал, Засгийн газраас баталсан болон аймгийн удирдлагын шийдвэрийг хяналтанд авах, хэрэгжүүлэх ажлыг бодлогын хэлтэс, хэрэгжүүлэгч байгууллагын хэмжээнд илүү нарийн тодорхой болгож, арга зүй мэдээллээр хангаж ажиллах зэрэг арга хэмжээг 2010 онд авч хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзэж байна.

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ ХИЙЖ, ТАЙЛАН ГАРГАСАН:

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ

ТАСГИЙН ДАРГА

Г. ХАНДАРМАА

МЭРГЭЖИЛТЭН

Ч. СҮРЭНХОРОЛ

В. ОТГОНБАТ

ХЯНАСАН:

ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

Б. ТҮВШИНБАЯР

